

“ТӨРӨӨС ХИЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО, ХИЛ ОРЧМЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА” ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

2005 оны 3 дугаар
сарын 4-ний өдөр

Улаанбаатар
хот

“Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, хил орчмын хамтын ажиллагаа” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн (ҮАБЗ) Ажлын алба, Хил хамгаалах ерөнхий газар (ХХЕГ), ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн (ОУСХ) хамтран 2005 оны 3 дугаар сарын 4-ний өдөр ХХЕГ-ын Мэдээллийн төвд зохион байгуулав.

Зөвлөлдөх уулзалтад төр засгийн холбогдох байгууллагын ажилтнууд, ҮАБЗ-ийн шинжээчид, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх эрдэмтэн, мэргэжилтнүүдийн зөвлөлийн зарим гишүүд, эрдэм шинжилгээ, сургалт судалгааны байгууллагын төлөөлөгчид, эрдэмтэд, судлаачид оролцож нийт 20 орчим илтгэл, мэдээлэл сонсож, хэлэлцүүлэг явуулав.

“Төрөөс хилийн талаар баримтлах бодлого” нь улсын хилийг бүх талаар баталгаажуулах, хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах арга замыг цогц байдлаар тусгасан залгамж чанартай баримт бичиг бөгөөд түүний үр дүнд хөрш улсуудтай хил, хил хамгаалалтын асуудлыг амжилттай шийдвэрлэсэн, хилийн бүх хэсгийн хамгаалалтыг ижил түвшинд хүргэсэн, хөрш орнуудын хил хамгаалах байгууллагууд, өөрийн орны холбогдох байгууллагуудтай хамтран ажилласнаар хил хамгаалалтад томоохон ахиц дэвшил гарсан байна.

Гэвч уг бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр, эрх зүйн баримт бичгүүд боловсрогдон гараагүй, хуулиар үүрэг хүлээсэн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа, холбоо шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаа зэрэг нь төрийн хилийн бодлогын хэрэгжилтэд тодорхой бэрхшээл учруулж байгааг уулзалтад оролцогсод онцлон тэмдэглэв.

Хөрш орнуудтай хил орчмын хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар Алтанбулаг, Замын-Үүдэд худалдааны болон эдийн засгийн чөлөөт бүс байгуулах хууль эрх зүйн үндсэн баримт бичгүүд батлагдан, Захирагчийн алба байгуулагдсан, БНХАУ-тай Хилийн боомтын хэлэлцээрийг шинэчилж, зарим боомтыг байнгын ажиллагаатай

болгосон гэх мэт нааштай эхлэлүүд хийгдсэн боловч улс орны хөгжилд нөлөө үзүүлэхүйц бодитой үр дүн харагдахгүй, ялангуяа Чөлөөт бүс байгуулах үйл явц удаашралтай байна.

Уулзалтад оролцогчдын тавьсан илтгэл, мэдээлэл, дүгнэлт, саналыг үндэслэн “Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт”-ийг эрчимжүүлэх хүрээнд дараах асуудлыг судлаж шийдвэрлэхийг **ЗӨВЛӨМЖ** болгох нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

- Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд оролцогч байгууллагуудын мөрдөж буй хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа, холбоог сайжруулах, чадавхи боломжийг нь нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг холбогдох яам, агентлаг, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран боловсруулж, ҮАБЗ-өөр хэлэлцэх бэлтгэлийг хангах,

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Дархан хил” үндэсний хөтөлбөрийн боловсруулалтад холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулан хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллуулах,

- БНХАУ Дэлхийн худалдааны байгууллагад элсч, түүний дүрэм, журмыг албан ёсоор даган мөрдөж эхэлсэн, ОХУ одоо элсэхээр шаргуу бэлтгэж буй таатай нөхцөл байдлыг хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх бодлогодоо оновчтой ашиглах, үүний тулд улс төр, дипломатын шугамаар хийх яриа хэлэлцээгээр дамжуулан нөлөөлөх арга хэмжээ авах,

- Хятадын талаас хилийн боомтыг хамтран хөгжүүлэх эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлж байсан. Энэ саналыг тал талаас нь судлан төрийн бодлогын анхааралд авах,

- Худалдааны болон улсын хил орчмын нийгэм, эдийн засгийн хөгжилд онцгойлон анхаарах, эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үйл явцыг түргэтгэхийн тулд хөрш орнуудын зах зээлийн судалгааг гүнзгийрүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах нөхцлийг бүрдүүлэх, улс орны бүсчилсэн хөгжилтэй нягт уялдуулах, орон нутгийн удирдлага менежментийг боловсронгуй болгох, олон улсын төсөл, хөтөлбөрт хамруулах ,

- Улсын хил, хил хамгаалалтын техник технологийн шинэчлэлтийг эрчимжүүлэх, хил хамгаалалтын чиглэлээр суурь судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлж, хил судлалын салбар шинжлэх

ухааныг хөгжүүлж улсын хил, түүний хамгаалалтын асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсронгуй болгох,

- Хөрш орнуудтайгаа хил орчмын байгаль орчны асуудлаар хамтын ажиллагааг өргөжүүлж хил дамнасан тусгай хамгаалалттай газруудыг хамтран байгуулах. Хил дагуух газар нутаг, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийг татан оролцуулах талаар төрийн бодлого боловсруулах,

- Хил орчимд үүссэн гал түймэр, үер, халдварт өвчин зэрэг гамшиг тохиолдсон үед хоёр хөрштэйгээ хамтарч түүнийг зогсоох, хор уршгийг нь хэрхэн арилгах талаар эрх зүйн харилцааг боловсронгуй болгох,

- ОХУ, Хятадын холбогдох байгууллагатай хамтран хил орчмын геологи, ашигт малтмал, экологийн зэрэг иж бүрэн зураг зохиох,

- Орос, Хятадын гадаад эдийн засгийн стратегид гарч буй шинэ хандлага, Монгол-Орос, Монгол-Хятадын худалдаа, түүний дотор хилийн худалдаа, хамтын ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар судалгаа хийж, дүгнэлт гаргах зэрэг болно.

Зөвлөлдөх уулзалтад оролцогсод